

**Ди Би Эм Лизинг ХХК**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан

(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

**АГУУЛГА****ХУУДАС**

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	<b>1</b>
АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	<b>2</b>
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	<b>3</b>
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	<b>4</b>
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	<b>5</b>

## Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Компанийн удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бodoх бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Компанийн удирдлага нь Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг тодруулгын хамт бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бodoх бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бodoх бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Ди Би Эм Лизинг ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Г. Пүрэвсүрэн  
ХХК  
Албан тушаал: Гүйцэтгэх Захирал

  
Б. Батаа  
Албан тушаал: Ерөнхий Нягтлан Бодогч

Монгол Улс,  
Улаанбаатар хот

2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар-14240,

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

Энхтайваны өргөн чөлөө 17

Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101

Факс: +976 7011 8102

[www.kpmg.com/mn](http://www.kpmg.com/mn)

## Хараат Бус Аудиторын Тайлан

"Ди Би Эм Лизинг" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид:

### Дүгнэлт

Бид "Ди Би Эм Лизинг" ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн санхүүгийн тайлан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЭЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу компаниас хараат бус байж, НБЭЗОУСЗ-ийн ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### Бусад асуудал

Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, аудитын зөрчилгүй дүгнэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан болно.

### Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланда хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайллагнах нь Компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулхтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мен энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд сүурilan санхүүгийн тайлангаа бэлтгэх үргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайллагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



## Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн үг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистай аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нэхцел байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мен бид олж авсан нотолгоондо тулгуурлан Компанийн тасралтгүй үл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц өргэлзээ үүсгэхүйц үл явдал, нэхцел байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үл явдал, эсвэл нэхцел байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн еренхий толилуулга, бутэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК

Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

УЛААНБААТАР ХОТ

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үл явдал, нэхцел байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг тайлан тусгаагүй болохыг анхаарна уу. Энэхүү тайланг зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ**  
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**(МИНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Тодруулга</b>	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	769,606	5,650,871
Хугацаатай хадгаламж	6	8,200,204	4,444,698
Түрээсийн авлага	7	67,776,257	33,559,097
Дансны болон бусад авлага	8	79,448	8,499
Бусад хөрөнгө	9	51,917	6,460
Түрээслэх зорилгоор худалдаж авсан хөрөнгө	10	5,900,000	-
Үндсэн хөрөнгө	11	295,443	126,035
Биет бус хөрөнгө		8,750	500
<b>Нийт хөрөнгө</b>		<b>83,081,625</b>	<b>43,796,160</b>
<b>Өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	12	5,993,567	62,930
Орлогын албан татварын өглөг		34,878	19,165
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	13	134,234	-
Зээл	14	66,124,130	33,626,642
<b>Нийт өр төлбөр</b>		<b>72,286,809</b>	<b>33,708,737</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	15	10,000,000	10,000,000
Хуримтлагдсан ашиг		794,816	87,423
<b>Нийт эздийн өмч</b>		<b>10,794,816</b>	<b>10,087,423</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>		<b>83,081,625</b>	<b>43,796,160</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Тод- руулга</b>	<b>2018</b>	<b>2017</b>
Хүүгийн орлого	16	4,239,874	1,014,581
Хүүгийн зардал	17	<u>(2,186,371)</u>	<u>(556,785)</u>
<b>Цэвэр хүүгийн орлого</b>		<b>2,053,503</b>	<b>457,796</b>
Үйл ажиллагааны зардал	18	(1,057,932)	(348,439)
Бусад үйл ажиллагааны орлого (зардал), цэвэр	19	<u>387,149</u>	<u>(1,902)</u>
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>1,382,720</b>	<b>107,455</b>
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	20	<u>(548,166)</u>	-
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>834,554</b>	<b>107,455</b>
Орлогын татварын зардал	21	<u>(127,161)</u>	<u>(20,032)</u>
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>707,393</b>	<b>87,423</b>
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>707,393</b>	<b>87,423</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Хувьцаат капитал</b>	<b>Хуриатлагд сан ашиг</b>	<b>Нийт эздийн өмч</b>
2017 оны 6 дугаар сарын 16-ны үлдэгдэл (үүсгэн байгуулагдах үед)	10,000,000	-	10,000,000
<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлого</b>			
Тайлант хугацааны цэвэр ашиг	-	87,423	87,423
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>			
	<b>10,000,000</b>	<b>87,423</b>	<b>10,087,423</b>
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	10,000,000	87,423	10,087,423
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>			
Тайлант жилийн цэвэр ашиг	-	707,393	707,393
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>			
	<b>10,000,000</b>	<b>794,816</b>	<b>10,794,816</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Тод- руулга</b>	<b>2018</b>	<b>2017</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Тайлан жилийн цэвэр ашиг		834,554	107,455
Тохируулгууд:			
Элэгдлийн зардал	11,18	39,271	13,791
Хүүгийн орлого	16	(4,239,874)	(1,014,581)
Хүүгийн зардал	17	2,186,371	556,785
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	20	548,166	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	19	(1,338)	-
Хэрэгжээгүй ханшийн зөрүүгийн цэвэр олз	19	(153,097)	(47,256)
		(785,947)	(383,806)
Хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт:			
Хугацаатай хадгаламжийн өсөлт	6	(3,557,951)	(4,449,458)
Түрээсийн авлагын өсөлт	7	(30,257,728)	(33,569,775)
Дансны болон бусад авлагын өсөлт	9	(70,949)	(8,499)
Бусад хөрөнгийн өсөлт		(130,667)	(6,460)
Түрээслэх зорилгоор худалдаж авсан хөрөнгийн өсөлт	10	(5,900,000)	-
Дансны болон бусад өглөгийн өсөлт	12	5,923,447	62,930
Төлсөн орлогын албан татвар		(111,448)	(867)
Хүлээн авсан хүүгийн орлого		4,301,109	519,960
Төлсөн хүүгийн зардал		(2,247,704)	-
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(32,837,838)</b>	<b>(37,835,975)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	11	(93,065)	(139,796)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(8,250)	-
Худалдсан тоног төхөөрөмж		27,025	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(74,290)</b>	<b>(139,796)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Санхүүгийн түрээсийн эргэн төлөлт	13	(7,834)	-
Хүлээн авсан зээл	14	39,120,491	33,626,642
Зээлийн эргэн төлөлт	14	(11,081,794)	-
Үүсгэн байгуулах үеийн хөрөнгө оруулалт	15	-	10,000,000
<b>Санхүүгийн үйл ажиллаагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>28,030,863</b>	<b>43,626,642</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн (бууралт) /өсөлт</b>		<b>(4,881,265)</b>	<b>5,650,871</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,650,871	-
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	5	<b>769,606</b>	<b>5,650,871</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт**

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид "Компани" гэх) нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан. Компанийг Монгол Улсын Хөгжлийн Банк бүрэн эзэмшдэг. Компанийн регистрийн дугаар нь 6196233 болно. Компанийн албан ёсны хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, "East Plaza" 39-р байр болно.

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан хуулын этгээд бөгөөд Монгол Улсын санхүүгийн түрээсийн тухай хууль, Иргэний хууль, Хөгжлийн Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн түрээсүүдийг олгодог. Компани нь стратегийн ач холбогдолтой салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтэд хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг.

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй**

**2.1 Тайлagnalын нийцэл**

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөөс баталсан Санхүүгийн Тайлagnalын Олон Улсын Стандартуудын (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн болно. Энэхүү санхүүгийн тайлан нь СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-ийг мөрдсөн анхны санхүүгийн тайлан болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг Тодруулга 2.3-д толилуулсан болно. Компанийн удирдлагаас 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зөвшөөрч баталсан.

**2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг тусгайлсан хэсэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлсэн.

**2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

Компани нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн анх СТОУС 15, тодруулга (A) болон СТОУС 9 тодруулга (B)-ийг мөрдөж эхэлсэн. Бусад хэд хэдэн шинэ стандартууд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн боловч эдгээр стандартууд нь Компанийн санхүүгийн тайландаа материаллаг нөлөөгүй.

Эдгээр стандартуудыг мөрдөхөөр сонгосон шилжилтийн аргуудаас хамааран дансны авлагын үнэ цэнийн бууралтын гарзыг тусад нь илэрхийлсэнээс бусдаар харьцуулагдах мэдээллийг дахин тайлagnaaагүй болно.

**(А) СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого**

Компани нь СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого стандартыг ашигладаг ба энэхүү стандарт нь НББОУС 18 Орлого, НББОУС 11 Барилгын гэрээ, СТХ 31 Орлого-Зар сурталчилгааны үйлчилгээтэй холбоотой бартерын гүйлгээ, СТОУТХ 13 Хэрэглэгчийн урамшууллын хөтөлбөр, СТОУТХ 15 Барилга байгуулалтын тухай гэрээ болон СТОУТХ 18 Хэрэглэгчийн хөрөнгийг шилжүүлэх стандарт болж өөрчлөгдсөн.

Бараа бүтээгдэхүүн борлуулсан орлого, үйлчилгээ үзүүлсэн орлого, хүүгийн, гишүүнчлэлийн, ногдол ашгийн болон барилгын гэрээ зэрэг гүйлгээнүүдийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг НББОУС 18 болон бусад стандартууд тодорхой заасан байдаг. Гэвч шинэ стандарт СТОУС 15-д дараах 5-н алхамын аргаар орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд: 1. Гэрээг тодорхойлох → 2. Гүйцэтгэлийн үүргийг тодорхойлох → 3. Гүйлгээний дүнг тооцоолох → 4. Гүйлгээний дүнг гүйцэтгэлийн үүрэгт хуваарьлах → 5. Гүйцэтгэлийн үүрэгт үндэслэн орлогыг хүлээн зөвшөөрдөг.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт (үргэлжлэл)**

Компани 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр СТОУС 15-ын нөлөөллийг судлан уг стандартыг мөрдсөнөөр санхүүгийн тайланд томоохон нөлөө орохгүй гэсэн дүгнэлт гаргасан. 2018 онд санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлсэн гүйлгээ гараагүй.

**(Б) СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр**

СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр болон санхүүгийн бус зүйлсийг худалдан авах эсвэл худалдах зарим гэрээг хүлээн зөвшөөрөх, хэмжих шаардлагыг тогтоодог. Энэхүү стандарт нь НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт – ийг орлох болсон.

2018 оны 1 сарын 1-ний өдрөөс СТОУС 9-ийг мөрдөж эхэлсэнээр Компани нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын нэмэлт өөрчлөлтийг мөрдөх болсон ба энэ нь бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь НББОУС 39 стандарттай ижилхэн "Санхүүгийн зардал"-ын доор толилуулагдах ба томоохон нөлөөллөөс шалтгаалан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнахгүй.

Мөн Компани нь СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга стандартыг мөрдөж эхэлсэн ба уг стандарт нь 2018 оны санхүүгийн тодруулгад хамаарах боловч харьцуулалтын мэдээлэлд нөлөөлөхгүй.

**Ангилал ба хэмжилт**

СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийн үндсэн гурван ангилалтай: хорогдуулсан өртгөөр хэмжсэн, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлсэн (БДОБҮЦ) болон ашиг, алдагдаарх бодит үнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө (ААБҮЦСХ) багтана. СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хөрөнгийн ангилал нь ерөнхийдөө тухайн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнес загвар болон түүний мөнгөн ургаслын шинж чанарт үндэслэдэг. Стандарт нь одоогийн НББОУС 39-ийн хөрөнгийн ангилал болох дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө (ДХХЭСХ), зээл ба авлага, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө (ББСХ) гэх ангилал байхгүй болсон. СТОУС 9-ийн дагуу үндсэн гэрээ нь уг стандартын цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө байх гэрээнд агуулагдсан деривативыг тусад нь салгаж үздэггүй ба ангилалыг тодорхойлоход хосолсон санхүүгийн хэрэглүүрийг бүхэлд нь үнэлдэг.

СТОУС 9 нь санхүүгийн өр төлбөрийн ангиллын хувьд НББОУС 39-ийн одоо мөрдөгдөж буй ихэнх шаардлагуудыг хэвээр үлдээсэн.

СТОУС 9-ийг нэвтрүүлсэн нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөртэй холбоотой Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй болно.

**Үнэ цэнийн бууралт**

СТОУС 9 нь НББОУС 39-ийн "алдагдал хүлээх үйл явдал тохиолдсон байх" гэсэн загварыг "хүлээгдэж буй алдагдал" (ХБА) хэмээх загвараар орлох болсон. Шинэ үнэ цэнийн бууралтын загварыг өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтаас бусад хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, БДОБҮЦ-ээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө болон гэрээний хөрөнгөд ашиглана. СТОУС 9-ийн дагуу зээлийн алдагдлыг НББОУС 39-өөс өмнө нь хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 9-ийн үнэ цэнийн бууралтын загварын хамрах хүрээнд хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг ерөнхийдөө нэмэгдүүлж, илүү тогтвортгүй болох төлөвтэй байна гэж үздэг. 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх хэрэгжиж эхэлсэн СТОУС 9-ийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн загварыг хэрэгжүүлсэнд дараа Компанийн үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын алдагдал нь материаллаг хэмжээгээр нэмэгдэхээргүй байна.

**2.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон анхны гэрээний хугацаа нь гурван сараас богино хугацаатай, бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд бага өртдөг, богино хугацаат үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг, хязгаарлагдаагүй, банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.5 Санхүүгийн хэрэгслүүд**

**(I) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд**

Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцөлд тал болох болсон үед санхүү байдлын тайланда санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Дансын авлагыг анх үүссэн үед нь анх хүлээн зөвшөөрдөг. Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцөлд тал болох болсон үед бусад бүх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрнө.

Анхны хүлээн зөвшөөрелтийн үед үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг (хэрэв идэвхитэй зах зээл дээр жишиг үнэ байхгүй тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр бүхий дансын авлага биш бол) ба санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнэ дээр тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмждэг. Идэвхитэй зах зээлд зах зээлийн жишиг үнээр арилжаалагдаггүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг түүний өргтгөр хэмжинэ.

**Санхүүгийн хөрөнгүүд – 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого**

Анх хүлээн зөвшөөрөхдөө санхүүгийн хөрөнгийг: хорогдуулсан өртөг, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ) – өрийн хөрөнгө оруулалт, БДОБҮЦ-ээр илэрхийлсэн өмчийн хөрөнгө оруулалт, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнийн аль нэгээр хэмжинэ. Компани санхүүгийн хөрөнгийг удирдах бизнес загвараа өөрчилснэөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн ангилалыг анхны хүлээн зөвшөөрелтийн дараа үед огт өөрчлөхгүй. Өөрөөр хэлбэл, бизнес загварын өөрчлөлтөнд орсон бүх санхүүгийн хөрөнгийг тухайн өөрчлөлт орсон анхны тайлант хугацааны эхний өдөр дахин ангилна.

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангаж байвал тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай; болон
- гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог;

Өрийн хөрөнгө оруулалт нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангаж байвал тухайн өрийн хөрөнгө оруулалтын санхүүгийн хөрөнгийг БДОБҮЦ-ээр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай; болон
- гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог

Дээр дурдсан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, эсвэл БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөр гэж ангилагдаагүй бүх санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмждэг.

**Санхүүгийн хөрөнгүүд – Бизнесийн загварын үнэлгээ: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого**

Компани нь бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн багцын түвшинд хийдэг бөгөөд энэ нь бизнесийг удирдаж буй арга замыг хамгийн сайн илэрхийлдэг ба удирдлага мэдээллээр хангагдсан байдаг. Авч үзсэн мэдээлэлд дараах зүйлс багтана:

- багцад зориулсан бодлого, зорилтууд, эдгээр бодлогын практик үйл ажиллагаа. Үүнд удирдлагын стратеги нь гэрээгээрх хүүгийн орлогоо олох, тодорхой хүүний түвшний үзүүлэлтийг хадгалах, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг түүнтэй холбоотой аливаа өр төлбөрийн хугацаа эсвэл хүлээгдэж буй мөнгөн зарлагын урсгал эсвэл хөрөнгийг борлуулснаар бий болох мөнгөн гүйлгээтэй тохишуулах эсэх;
- багцийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, Компанийн удирдлагад тайлагнаасан эсэх;
- бизнесийн загварт (мөн тухайн бизнесийн загварт багтсан санхүүгийн хөрөнгүүдэд) гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа эсэх;
- бизнесийн менежерүүдийг хэрхэн урамшуулалыг хэрхэн олгодог вэ – жишээ нь олговор нь хөрөнгийн бодит үнэ цэнээр эсвэл хуримтлагдсан гэрээний мөнгөн гүйлгээний үнэд суурилсан эсэх; болон
- өмнөх хугацааны санхүүгийн хөрөнгийн борлуулалтын давтамж, хэмжээ, хугацаа, энэхүү борлуулалтын шалтгаанууд болон ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны хүлээлт

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.5 Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

Санхүүгийн хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангахгүй байх тохиолдолд үүнийг борлуулалт гэж авч үзэхгүй бөгөөд Компанийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх зарчмитай нийтэй байна.

Арилжаалах зорилгоор эзэмшиж эсвэл удирдаж буй бөгөөд гүйцэтгэлийг бодит үнэ цэнэд суурилан үнэлдэг санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмждэг.

**Санхүүгийн хөрөнгүүд** – Гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрөөс бүрдсэн эсэхийн үнэлгээ: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого

Энэ үнэлгээний зорилгоор 'үндсэн' гэж анх хүлээн зөвшөөрсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэлнэ. "Хүү" гэдэг нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба тодорхой хугацааны туршид эргэлтэнд байгаа үндсэн дүнтэй холбоотой зээлийн эрсдэлийн хувьд болон үндсэн зээлийн бусад эрсдэл, ертөг (жишээлбэл, хөрвөх чадварын эрсдэл ба захирагааны зардал гэх мэт), мөн түүнчлэн ашгийн зөрүүг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийн гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн зориулалттай байгаа эсэхийг үнэлэхэд Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцлийг авч үздэг. Үүнд санхүүгийн хөрөнгө нь энэ нөхцөлийг хангаж чадахгүй байхаар ямар нэгэн гэрээний мөнгөн гүйлгээний цаг хугацаа буюу дүнг өөрчлөх боломжтой нөхцөл агуулдаг эсэхийг үнэлэхэд оршино. Энэ үнэлгээг хийхдээ Компани дараах зүйлсийг авч үзсэн болно:

- мөнгөн гүйлгээний дүн буюу хугацааг өөрчлөхөд гарах болзошгүй үйл явдал;
- гэрээний купоны ханш, хувьсах хэмжигдэхүүний шинж чанарыг багтаасан болзошгүй нөхцлүүд;
- урьдчилгаа төлбөр ба өргөтгөлийн онцлог; болон
- Компанийг тодорхой хөрөнгөөс авах үр ашгийг хязгаарласан нөхцөлүүд (жишээ нь буцаах эрхгүй нөхцөлүүд).

Урьдчилсан төлбөрийн дүн нь үндсэн төлбөр ба зээлийн хүүгийн төлбөрийг үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн дүнгээр барагдуулсан бол гэрээний эрт дуусгавар болох үндэслэлтэй нэмэлт нөхөн төлбөрийг багтааж болно. Хөнгөлөлттэй эсвэл гэрээнд заасан урамшуулалтай үнээр худалдан авсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, урьдчилгаа төлбөр нь гэрээнд тусгасан нээрлэсэн дүн болон (төвлөгөөгүй байгаа) гэрээнд тусгасан хүүгийн хуримтлагдсан дүнгээр (мөн гэрээг заасан хугацаанаас өмнө цуцласны нэмэгдэл нөхөн олговрыг тооцсон байж болно) бодитойгоор хүлээн зөвшөөрч тайлاغнасан байвал зөв тайлагнасан болох бөгөөд, урьдчилж төлсөн төлбөрийг анхны хүлээн зөвшөөрлөлтөөр зөвшөөрвэл бодит үнэ цэнэ нь ач холбогдолгүй болох юм.

**Санхүүгийн хөрөнгө – Дараа үеийн хэмжилт болон олз ба гарз: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого**

ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайланд үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмждэг. Аливаа хүүгийн орлого эсвэл ногдол ашгийн орлого зэрэг багтсан цэвэр олз ба гарзыг х ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Хорогдуулсан өртөгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үеүдэд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Хорогдуулсан өртгийг үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулдаг. Хүүгийн орлого, гадаад валютын ханшийн олз, гарз ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Аливаа үл хүлээн зөвшөөрлөлтөөс үүссэн олз эсвэл гарзыг ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрдөг.

**Санхүүгийн хөрөнгүүд - 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хэрэгжсэн бодлого**

Компани үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг дараах ангиллын дагуу хүлээн зөвшөөрч, хэмждэг: зээл ба авлага, борлуулахад бэлэн хөрөнгө орно. Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөл зөвхөн компанид хамааралтай болох тэр үед санхүүгийн байдлын тайландaa хүлээн зөвшөөрдөг. Анхны хүлээн зөвшөөрлтийн үед үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг түүний бодит үнэ цэнэ дээр тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмждэг.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.5 Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

Дансны болон бусад авлага

Идэвхитэй зах зээл дээр жишиг үнэ байхгүй тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр бүхий санхүүгийн хөрөнгийг дансны болон бусад авлага гэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед дансны болон бусад авлагыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг.

Борлуулахад бэлэн хөрөнгө

Борлуулахад бэлэн хөрөнгө гэдэг нь борлуулах боломжтой, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт аль эсвэл зээл болон авлага гэж ангилагдаагүй үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба аливаа татварын цэвэр нөлөөг хассан бодит үнэ цэнэ дэх өөрчлөлтийг өмчийн бусад дэлгэрэнгүй орлого хэсэгт тайлagnана. Идэвхитэй зах зээлд зах зээлийн жишиг үнээр арилжаалагддаггүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг түүний өртгөөр хэмжинэ. Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрэх эсвэл үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнөх үеийн бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз эсвэл гарзыг өмчөөс ашиг эсвэл алдагдал руу дахин ангилна. Компанийн төлбөр хүлээн авах эрх хэрэгжих үед борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрээрх хөрөнгөнд хүлээн авсан ногдол ашигийг ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

**Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх**

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор шилжүүлсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг. Уг гүйлгээгээр бий болсон эсвэл үлдсэн аливаа эрх, үүргийг тусад нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Хэрэв компани уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх ба холбогдох санхүүгийн өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрдөг.

**(ii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр**

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл тухайн хэрэглүүрийн гэрээний нөхцөл, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын дагуу бусад санхүүгийн өр төлбөр хэмээн ангилдаг. Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийн нэг хэсэг болсон тохиолдолд уг санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр**

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтын санхүүгийн өр төлбөр болон уг байдлаар анх хүлээн зөвшөөрөгдсөн өр төлбөрийг оруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих ба өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олж авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Бусад санхүүгийн өр төлбөр**

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрт ангилна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеэр бусад санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээс худалдан авалттай шууд хамаарал бүхий ажил гүйлгээний зардлыг хассан дүнгээр хэмждэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг дуусгавар болох үед нь (гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон гэх мэт) санхүүгийн байдлын тайландаа үл хүлээн зөвшөөрдөг.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.5 Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

(ii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дунг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

**2.6 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

*2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого*

Компани нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын (ХБА) санг дараах санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрдөг:

- хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгө;
- БДОБҮЦ-ээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө; ба
- гэрээний хөрөнгө.

Компани дор заасан 12 сарын хугацаанд ХБА-ын хэмжээгээр хэмжснээс бусад тохиолдолд зээлийн алдагдлын санг, нийт гэрээний хугацаанд ХБА-ын сантай тэнцэх хэмжээгээр тооцдог:

- тайлагналын өдрөөр зээлийн эрсдэл бага байхаар тодорхойлогдсон өрийн үнэт цаас; болон
- бусад өрийн үнэт цаас болон банкны балансны зээлийн эрсдэл нь (өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүрийн гэрээний хугацааны туршид үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл) анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц өсөөгүй.

Дансны авлага болон гэрээний хөрөнгийн хувьд алдагдлыг үргэлж гэрээний хугацаатай тэнцэх ХБА-тай байхаар хэмждэг.

Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш болон ХБА-г тооцох үед мэдэгдэхүйц хэмжээнд нэмэгдсэн эсэхийг тодорхойлоходоо Компани үндэслэлтэй бөгөөд дэмжлэг болох холбоотой бөгөөд аливаа өртөг, хүчин чармайлт гаргалгүй олж авах боломжтой мэдээллийг авч үздэг. Энэ нь компанийн түүхэн туршлага, мэдээлэлд тулгуурласан зээлийн үнэлгээ болон ирээдүйн мэдээллийг багтаасан тоон болон чанарын мэдээлэл, дүн шинжилгээг багтаадаг.

Компани нь санхүүгийн хөрөнгийн эргэн төлөлтийн хугацаа 30 хоногоос хэтэрсэн тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн гэж үздэг.

Компани санхүүгийн хөрөнгийг дараах нөхцөлд хугацаа хэтэрч, үүргээ биелүүлэхгүй гэж үздэг:

- компани зээлдэг нь үнэт цаасыг хүчээр зарах (хэрэв байгаа бол) гэх мэт аливаа арга хэмжээ авахгүйгээр компаний эргэн төлөх үүргээ бүрэн биелүүлж чадахгүй тохиолдолд; эсвэл
- санхүүгийн хөрөнгө 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн

Гэрээний хугацаа дуусах хүртэл ХБА нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний хугацааны туршид тохиолдох боломжтой бүхий л хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх ХБА-ийн хэсэг юм.

12 сарын ХБА нь тайлант жил дуусгавар болсон өдрөөс хойш 12 сарын хугацаанд (эсвэл хэрэглүүрийн гэрээний хугацаа нь 12 сараас бага бол богино хугацаанд үүссэн үйл явдал) тохиолдож болзошгүй хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх ХБА-ийн хэсэг юм.

ХБА-г тооцохдоо авч үздэг хамгийн урт хугацаа нь компанийн зээлийн эрсдэлд өртөх гэрээний хамгийн урт хугацаа юм.

Компани нь санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Хөрөнгийг анх бүртгэснээс хойш алдагдалд хүргэх үйл явдал болсон бөгөөд уг үйл явдлын улмаас тухайн хөрөнгийн ирээдүйд бий болгох мөнгөн урсгал буурсан байвал уг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.6 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- 90 хонгоос дээш эргэн төлөх хугацаа хэтэрсэн эсвэл гэрээний үүргээ биелүүлэх чадваргүй болсон зэргээр гэрээний заалтыг зөрчсөн;
- Компанид өөр нөхцөл байхгүй байсантай холбоотой зээл болон урьдчилгаа төлбөрийн бүтцийг өөрчилсөн;
- зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай;
- санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй болсон

Хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн дансны үнээс бууруулдаг.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үнэт цаасны хувьд алдагдлын санг ашиг, алдагдлын хэсэгт тусган бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна. Корпорацийн үйлчлүүлэгчдийн хувьд, Компани нь тусдаа нөхөн төлбөрийн боломжит таамаглал байгаа эсэхийг цаг хугацаа болон дүнт харгалзан үнэлгээ хийдэг. Компани данснаас хассан дүнгээс их хэмжээний дун нөхөгдөнө гэж үздэггүй боловч Компанийн төлбөр барагдуулах журмын дагуу данснаас хасагдсан санхүүгийн хөрөнгийг хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээ авч байж болно.

**2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хэрэгжсэн бодлого**

Санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Хөрөнгийг анх бүртгэснээс хойш алдагдалд хүргэх үйл явдал болсон гэдгийн бодит нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдлын улмаас тухайн хөрөнгийн ирээдүйд бий болгох мөнгөн урсгал буурахыг найдвартайгаар тооцоолж болохоор байвал уг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ. Гэхдээ магадлалыг үл харгалзан, ирээдүйн үйл явдлын үр дүнд хүлээгдэж буй гарзыг хүлээн зөвшөөрдөггүй.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- хүүгийн болон үндсэн төлбөрийг үл төлөх, гэрээг үл биелүүлэх гэх мэтээр гэрээний заалтыг зөрчих;
- аливаа эдийн засгийн болон хууль зүйн шалтгааны улмаас зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд зээлдүүлэгч, зээлдэгчид хөнгөлөлт эдлүүлэх;
- зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай байгаа;
- санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй болсон эсвэл;
- бүлэг санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрлөлтөөс хойш тэдгээр хөрөнгүүдийн ирээдүйн тооцоологдсон мөнгөн урсгалд хэмжигдэхүйц бууралтын шинж тэмдэг ажиглагдсан боловч бүлэг санхүүгийн хөрөнгөөс тухайн хөрөнгийн бууралтыг тусад нь тодорхойлох боломжгүй байх

Мөн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хувьд бодит үнэ цэнэ нь өртгөөс бага байгаа тохиолдолд үүсэх нэлээд хэмжээний бууралт нь үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо юм.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт үүссэн бодит нотолгоо байгаа бол уг үнэ цэнийн бууралтын гарз нь хүлээн зөвшөөрөгдөн хэмжигдэхүйц байх ёстой.

(i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгетэй холбоотойгоор үүсэх үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ болон хөрөнгийн анхны үр ашигт хүүгийн түвшний хувиар дискаунтчилсан ирээдүйн тооцоологдсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн хоорондын зөрүүгээр тооцдог. Хэрэв дараагийн тайлант үед үнэ цэнийн бууралтын гарзын дун буурч, уг бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа үед тохиолдсон үйл явдалтай (тухайлбал: зээлдэгчийн зээлийн ангилал дээшилсэн гэх мэт) бодитоогоор холбоотой бол өмнө нь хүлээн зөвшөөрсэн үнэ цэнийн бууралтын гарзыг шууд эсвэл хасагдуулгын дансыг тохируулах замаар буцаадаг.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.6 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

2018 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс өмнө хэрэгжсэн бодлого (үргэлжлэл)

(ii) Өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнийг нь найдвартай тооцоолох боломжгүйгээс бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй өмчийн хэрэглүүр эсвэл үнэ тогтоогдоогүй өмчийн хэрэглүүртэй холбоотой мөн түүгээр илэрхийлэгдэх үүсмэл хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз тохиолдсон бодитой нотолгоо байгаа үед уг үнэ цэнийн бууралт нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнэ болон ижил терлийн санхүүгийн хөрөнгийн өнөөгийн зах зээлийн хувиар дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн хоорондын зөрүүгээр тооцогдоно. Уг үнэ цэнийн бууралтын гарзыг буцаадаггүй.

**2.7 Үрьдчилгаа төлбөр**

Үрьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөрөөс бүрдэнэ. Үрьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Үрьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол үрьдчилгаа төлбөрийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Компани нь үрьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнийн цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

**2.8 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ.  
Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуриимтлагдсан элэгдэл болон хуриимтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шuluун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бodoх аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нелөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга ба эд хогшил	3 - 10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

**2.9 Эздийн өмч**

Энгийн хувьцаа нь эздийн өмчид ангилагдна. Шинэ хувьцаа гаргахтай холбоотой гадаад зардлууд нь эздийн өмчид бүртгэгдэх энгийн хувьцааны дүнгээс хасагдсан байдалтайгаар хүлээн зөвшөөрнө. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ болон бодит үнийн зөрүүг нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.9 Эздийн өмч (үргэлжлэл)**

Ногдол ашгийг зөвхөн тайланд өдөр болон түүнээс өмнө зарлагдсан тохиолдолд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, тайлант өдөр эздийн өмчөөс хасна. Мен ногдол ашгийг тайлант өдрийн өмнө санал болгосон эсвэл тайлант өдөр болон санхүүгийн тайлан баталгаажих өдрийн хооронд санал болгосон тохиолдолд тодруулга хийнэ.

**2.10 Түрээс**

*(i) Ангилал*

Компани түрээсийн хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон эрсдэл ба өгөөж нь түрээслэгч эсвэл түрээслүүлэгчид ямар хэмжээнд хамаарч байгаад үндэслэн түрээсийн ангиллыг хийдэг.

Түрээсийг дараах тохиолдолуудад санхүүгийн түрээс гэж ангилна. Үүнд: (i) түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийн өмчлөх эрхийг түрээслэгчид шилжүүлдэг бол, (ii) сонголтын эрх хэрэгжих өдрийн бодит үнэ цэнээс мэдэгдэхүйц бага үнээр уг хөрөнгийг түрээслэгч нь худалдан авах сонголтын эрхтэй учир уг сонголтын эрх хэрэгжих нь ул үндэслэлтэйгээр түрээсийн эхэнд тодорхой болсон бол, (iii) хэдийгээр эрх нь шилжээгүй байсан ч түрээсийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын хугацааны ихэнх хугацаа бол, (iv) түрээсийн эхэнд тогтоосон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь түрээслэсэн хөрөнгийн бараг бүх бодит үнэ цэнэтэй дүйцэхүйц бол, (v) зөвхөн түрээслэгч ямар нэг томоохон өөрчлөлт хийхгүйгээр ашиглаж болох онцгой шинж чанар бүхий түрээслэн хөрөнгө байх.

*(ii) Санхүүгийн түрээс*

Компани түрээсийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байвал уг түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилна. Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дунгээр авлага бүртгэнэ. Түрээсийн гэрээ хийхтэй холбоотой боловч уг гэрээ нь санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хараахан хэрэгжээгүй байх үед гарсан зардлыг урьдчилж төлсөн түрээсийн хөрөнгө гэж бүртгэх бөгөөд хэрэгжих үед нь санхүүгийн түрээсийн авлага руу дахин ангилж бүртгэнэ. Түрээсийн авлага нь түрээсийн хэлцэл хийх, түүнийг баталгаажуулхтай хамааралтай гарсан шимтгэл, хураамжийн төлбөр, хуулын төлбөр болон бусад дотоод зардал гэх зэрэг анхдагч шууд зардуудыг багтаасан байдаг. Түрээсийн төлбөр бүрийг үндсэн болон санхүүгийн орлого гэж хуваан бүртгэнэ. Цэвэр хөрөнгө оруулалтын төлөгдөөгүй хэсэгт хамаарах санхүүгийн орлогыг түрээсийн хугацаанд училсан байдлаар хуваарилдаг бөгөөд ингэснээр өр төлбөрийн үлдэгдэл дунд үучилсан тогтмол түвшинг тусгаж өгч байгаа юм.

*(iii) Үйл ажиллагааны түрээс*

Үйл ажиллагааны түрээсийн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэлийг хассан цэвэр худалдан авалтын өртгөөр бүртгэдэг. Түрээсийн гэрээ хийхтэй холбоотой боловч уг гэрээ нь санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хараахан хэрэгжээгүй байх үед гарсан зардлыг урьдчилж төлсөн түрээсийн хөрөнгө гэж бүртгэх бөгөөд хэрэгжих үед нь үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөр ангилж бүртгэнэ. Аливаа баталгаат үлдэх үнэ цэнээс бусад үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар орлого болгон тайлагнадаг. Үйл ажиллагааны түрээсийн хэлэлцээр хийхтэй холбоотой гарсан анхдагч шууд зардлыг үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх бөгөөд түрээсийн орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй ижил сууриар түрээсийн хугацааны туршид хорогдуулж бүртгэнэ.

**2.11 Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт**

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн бодлого

Хүүгийн орлого болон зардал нь ашиг, алдагдлын тайланд үр ашигт хүүгийн аргаар бүртгэгдэнэ. Үр ашигт хүүгийн түвшин нь санхүүгийн хэрэгсэлийн бүх насхилтын турш дахь ирээдүйн мөнгөн зардал ба орлогыг дараах байдлаар хорогдуулдаг:

- Санхүүгийн хөрөнгийн нийт өртөг, эсвэл
- Санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг

Худалдан авсан эсвэл зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгийн түвшинг тооцоолоход Компани нь хүлээгдэж буй зээлийн алдагдлаас бусад санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний нөхцлийн ирээдүйн мөнгөн урсгалыг ашиглана. Худалдан авсан эсвэл зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн залруулсан үр ашигт хүүгийн түвшинг зээлийн алдагдлыг оруулан ирээдүйн мөнгөн урсгалыг ашиглан тооцоолно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МИНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.11 Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

Үр ашигт хүүгийн түвшинг тооцоолоход ажил гүйлгээний зардал ба төлбөр болон үр ашигт хүүгийн түвшний гол хэсгүүдийн төлсөн болон хүлээн авсан төлбөрүүд багтана. Ажил гүйлгээний өртөгт санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг худалдан авах эсвэл зарж борлуулхтай холбоотой гарсан нэмэгдэх зардууд орно.

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн "хорогдуулсан өртөг" гэж санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дүнгээс үндсэн төлбөрийг дүнг хасан анхны болон дуусах хугацааны үнэ цэнийн хоорондох зөрүүн дээрхи үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцсон хуримтлагдсан хорогдлын дүнг нэмэх эсвэл хасах бөгөөд санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн эрсд^лийн сан (эсвэл 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх үнэ цэнийн бууралтын нөөц)-г залруулна.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн "санхүүгийн хөрөнгийн нийт дансны өртөг" нь хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн санд залруулга орохоос өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулгын өртөг юм.

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хэрэгжсэн бодлого

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэгсэлүүдийн хувьд, "Борлуулахад бэлэн" гэж ангилагдсан хүйтэй санхүүгийн хөрөнгүүд, "Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх" гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувийг (ирээдүйд төлөх эсхүл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсхүл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүн хүртэл буурвулах хүү) хэрэглэн бүртгэнэ.

Тооцоололд санхүүгийн хэрэгсэлүүдийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба санхүүгийн хэрэгсэлтэй шууд холбоотой нэмэгдэх зардууд болон зээлийн ирээдүйн алдагдаас бусад EIR-ын чухал хэсгүүд тусгагдсан.

Компани төлбөр төлөх болон хүлээн авах мөнгөний талаар хийсэн өөрийн тооцоололдоо өөрчлөлт оруулбал санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүнд залруулга хийнэ. Залруулсан бүртгэлийн дүнг анхны үр ашигт хүүгийн түвшин дээр үндэслэн тооцоолох ба бүртгэлийн дүнгийн зөрүүг ашиг алдагдаа бүртгэдэг. Гэхдээ ирээдүйд хүлээн авах мөнгөний хэмжээ өссөний улмаас Компани ирээдүйд хүлээн авах мөнгөний тооцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нелөөг тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн "Үр ашигт хүүгийн түвшинд хийсэн залруулга" гэж хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас буурвуулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг буурвулахдаа хэрэглэсэн хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

**2.12 Ажилчдын тэтгэмж**

Компани нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн Компани нь ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ Компани нь ажилчдынхаа үзүүлсэн өнгөрсөн үеийн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

**2.13 Нөөц**

Компани нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.13 Нөөц (үргэлжлэл)**

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

**2.14 Холбоотой тал**

Компани болон Компанийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ.

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг;
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- Компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан.

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанийд багтдаг охин компанийд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан доор байх;
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан;

**2.15 Татвар**

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

**2.15.1 Тухайн жилийн орлогын албан татвар**

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайландаа тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.15 Татвар (үргэлжлэл)**

**2.11.1 Хойшлогдсон татвар**

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвил болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө бө өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрөөр Компани хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

**2.11.2 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар**

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсэн орлого, зардлын дунд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

**3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж**

**3.1.1 Монгол Улсын татварын систем**

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбер торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)**

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Дараах санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

**3.2.1 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил**

Компани үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой. Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

**3.2.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

СТОУС 9 нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих хүлээн зөвшөөрөх арга хандлагыг боловсруулсан. Компани санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор тайлагнالын өдрөөр санхүүгийн хөрөнгийн дансны үнийг хянадаг бөгөөд түрээслэгч бүрийн нөхцөл байдалд үндэслэн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг үнэлдэг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоходо ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоход ашигласан таамаглал болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын түвшинг тодорхойлоход удирдлагын үнэлэмжийг авч үздэг. Мөнгөн урсгалын тооцоололд авч үзсэн эдгээр таамаглалд орсон аливаа өөрчлөлтийн үр дүнд үнэ цэнийн бууралтын алдагдлын сан өсөх эсвэл буурах бөгөөд энэ нь Компанийн бодит үнэ цэнэд нөлөөлнө. Нягтлан бодох бүртгэлийн холбогдох бодлогын дэлгэрэнгүйг Тодруулга 2.6-аас харна уу.

**4. Мөрдөж эхлээгүй байгаа шинээр гарсан стандартууд**

Одоогийн шинэ стандартууд дээр дараах шинэ стандартууд, тайлбарууд, болон нэмэлт өөрчлөлтүүд нийтлэгдсэн ба 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд Компани эдгээрийг эрт хэрэгжүүлээгүй.

**СТОУС 16 Түрээс**

СТОУС 16 нь санхүүгийн түрээслэгчдэд зориулсан санхүүгийн түрээсийн баланс дахь бүртгэлийг нэвтрүүлсэн. Түрээслэгч нь үндсэн хөрөнгийн үндсэн хөрөнгийг ашиглах эрхийг илэрхийлж буй хөрөнгө-ашиглах-эрхийг болон түрээсийн төлбөр төлөх үүргийг илэрхийлж буй түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Богино хугацаат түрээс болон бага өртөгт санхүүгийн түрээсүүд дээр чөлөөлөгдхөх боломжтой. Түрээслэгчийн бүртгэлийн стандарт нь одоогийн стандарттаас өөрчлөгдөөгүй ба түрээслэгч нь түрээсийг санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсээр ангилсан хэвээрээ байна.

СТОУС 16 нь одоо мөрдөгдэж буй НББОУС 17 Түрээс, НББОУСХТ 4 Хэлцэлд түрээсийн шинж чанар агуулагдсан эсэхийг тодорхойлох, СТХ 15 Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал болон СТХ 27 Түрээсийн хууль эрх зүйтэй холбоотой гүйлгээний агуулгыг дүгнэх зэрэг стандартуудыг орлоно.

**СТОУС 16 Түрээс (үргэлжлэл)**

Стандарт нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлнэ. СТОУС 16-ийг мөрдөж эхлэхээс өмнө СТОУС 15 Үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээний орлого стандартыг мөрдөж байсан компаниуд нь уг стандартыг эрт нэвтрүүлэх боломжгүй юм.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**4. Мөрдэж эхлээгүй байгаа шинээр гарсан стандартууд (үргэлжлэл)**

**Бусад стандартууд**

Дараах стандартуудын өөрчлөлтүүдийн Компанийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл нь материаллаг бус гэж үзэж байна:

- НББОУСХТ 23 Татварын бүртгэлийн тодорхой бус байдал
- Сөрөг нөхөн төлбөртэй урьдчилгаа төлбөр (СТОУС 9-д орсон өөрчлөлт)
- Хараат болон хамтарсан компани дах урт хугацааны ашиг сонирхол (НББОУС 28-д орсон өөрчлөлт)
- Төлөвлөгөөний өөрчлөлт, цомхотгол эсвэл шийдвэрлэлт (НББОУС 19-д орсон өөрчлөлт)
- 2015-2017 оны СТОУС-ын жилийн сайжруулалт (стандартууд)
- СТОУС дах үзэл баримтлалын хүрээнд өөрчлөлт оруулах
- СТОУС 17 Даатгалын гэрээ

**5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Бэлэн мөнгө	85	91
Харилцах данс	769,521	275,026
Хугацаатай хадгаламж (3 сар хүртэлх)	-	5,375,754
	<b>769,606</b>	<b>5,650,871</b>

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаатай, өндөр хөрвөх чадвар бүхий хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай байдгаараа онцлог юм.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг барьцаагаар хангах шаардлагагүй бөгөөд хугацааны болон үнэ цэнийн бууралт тооцох үзүүлэлтээр ангилах шаардлагагүй байдаг.

Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон хугацаатай хадгаламжийн эрсдэлийг Стандарт энд Пүүрс, Мүүдийз болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
B3	338,814	-
Caa1	-	2,021,256
Зэрэглэлгүй	430,707	3,629,524
	<b>769,521</b>	<b>5,650,780</b>

**6. Хугацаатай хадгаламж**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Мөнгөн хадгаламж	8,240,476	4,444,698
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(40,272)	-
	<b>8,200,204</b>	<b>4,444,698</b>

Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж нь 3 сараас дээш хугацаатай хадгаламжуудаас бүрдэнэ.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**6. Хугацаатай хадгаламж (үргэлжлэл)**

Банкин дахь хугацаатай хадгаламжийн эрсдэлийг Стандарт энд Пүүрс, Мүүдийз болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
<b>Эргэлтийн</b>		
Зэрэглэлгүй	8,240,476	4,444,698

**7. Түрээсийн авлага**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Түрээсийн авлага	67,620,792	32,958,370
Хуримтлагдсан хүүгийн авлага	663,359	600,727
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан	(507,894)	-

Санхүүгийн түрээсийн авлагын насхилт дараах байдалтай байна.

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>		
	<b>Түрээсийн авлага</b>	<b>Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан</b>	<b>Түрээсийн авлага</b>	<b>Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан</b>
<b>Хугацаа хэтэрсэн хоног</b>				
0-30 хоног	65,951,746	(330,975)	32,958,370	-
31-90 хоног	1,669,046	(176,919)	-	-
91-180 хоног	-	-	-	-
181-360 хоног	-	-	-	-
360-аас дээш хоног	-	-	-	-
	<b>67,620,792</b>	<b>(507,894)</b>	<b>32,958,370</b>	<b>-</b>

Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	-	-
Үнэ цэнийн бууралтын хөдөлгөөн	(507,894)	-
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<b>(507,894)</b>	<b>-</b>

**8. Дансны болон бусад авлага**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Дансны авлага	60,590	8,236
Ажилчдаас авах авлага	1,834	263
Бусад авлага	17,024	-

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**9. Бусад хөрөнгө**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Урьдчилгаа	37,195	1,792
Бараа материал	14,722	4,668
	<b>51,917</b>	<b>6,460</b>

**10. Санхүүгийн түрээсийн зорилгоор худалдаж авсан хөрөнгө**

Компани нь уул уурхайн компанийд санхүүгийн түрээсээр олгох зорилгоор санхүүгийн түрээсийн хөрөнгө болох экскаваторыг 5.9 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд хөрөнгийн өмчлөлийг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлэн авсан боловч холбогдох санхүүгийн түрээсийн санхүүжилтийг тайлант жилийн дараа олгосон. Үүний үр дүнд, Компани 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн түрээсийн зорилгоор худалдаж авсан хөрөнгө бүртгэсэн.

**11. Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна:

	<b>Тавилга эд хогшил</b>	<b>Тээврийн хэрэгсэл</b>	<b>Компьютер</b>	<b>Нийт</b>
<b>Өртөг</b>				
2017.6.16	-	-	-	-
Нэмэгдсэн	54,864	48,554	71,666	175,084
Хасагдсан	-	(1,520)	(34,865)	(36,385)
Шилжүүлсэн	-	(940)	-	(940)
<b>2017.12.31</b>	<b>54,864</b>	<b>46,094</b>	<b>36,801</b>	<b>137,759</b>
2018.01.01	54,864	46,094	36,801	137,759
Нэмэгдсэн	157,000	37,587	39,778	234,365
Хасагдсан	(27,957)	-	-	(27,957)
<b>2018.12.31</b>	<b>183,907</b>	<b>83,681</b>	<b>76,579</b>	<b>344,167</b>
<b>Хуриатлагдсан элэгдэл</b>				
2017.6.16	-	-	-	-
Тайлант хугацаанд байгуулсан	(3,440)	(6,868)	(3,484)	(13,792)
Хасагдсан	-	356	1,712	2,068
<b>2017.12.31</b>	<b>(3,440)</b>	<b>(6,512)</b>	<b>(1,772)</b>	<b>(11,724)</b>
2018.01.01	(3,440)	(6,512)	(1,772)	(11,724)
Нэмэгдсэн	(14,565)	(18,794)	(5,911)	(39,270)
Хасагдсан	2,270	-	-	2,270
<b>2018.12.31</b>	<b>(15,735)</b>	<b>(25,306)</b>	<b>(7,683)</b>	<b>(48,724)</b>
<b>Дансны үнэ</b>				
<b>2017.12.31</b>	<b>51,424</b>	<b>39,582</b>	<b>35,029</b>	<b>126,035</b>
<b>2018.12.31</b>	<b>168,172</b>	<b>58,375</b>	<b>68,896</b>	<b>295,443</b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**12. Дансны болон бусад өглөг**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Дансны өглөг	5,991,233	46,454
Орлогын албан татварын өглөг	679	15,626
Бусад өглөг	1,655	850
	<b>5,993,567</b>	<b>62,930</b>

**13. Санхүүгийн түрээсийн өр төлбөр**

Компани нь Хаан Банк ХХК-иас 5 жилийн хугацаанд эргэн төлөгдөх хуваарь бүхий санхүүгийн түрээсийн гэрээгээр автомашин худалдан авсантай холбоотой үүссэн санхүүгийн түрээсийн өр төлбөрийг илэрхийлнэ.

**14. Зээл**

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Богино хугацаат зээл	9,023,236	5,042,812
Урт хугацаат зээл	57,100,894	28,583,830
	<b>66,124,130</b>	<b>33,626,642</b>

(1) Богино хугацаат зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна:

<b>Зээлдүүлэгч</b>	<b>Валют</b>	<b>Хүүгийн тувшин</b>	<b>Авсан огноо</b>	<b>Дуусах огноо</b>	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Монгол Улсын Хөгжлийн Банк	Ам.Доллар	3.60%	7/28/2017	7/28/2022	3,047,975	979,978
	Иен	5.95%	11/16/2017	5/29/2020	1,090,805	3,129,951
	Иен	4.89%	4/10/2018	4/10/2021	1,630,479	-
	Иен	4.89%	5/24/2018	4/10/2021	884,731	-
	Иен	6.50%	9/12/2018	9/12/2023	307,101	-
	Иен	6.50%	11/13/2018	9/12/2023	309,758	-
	Иен	6.50%	10/18/2018	9/12/2023	565,507	-
Сангийн Яам (*)	Төгрөг	2.25%	12/21/2017	7/28/2028	1,186,880	932,883
					<b>9,023,236</b>	<b>5,042,812</b>

(\*) Компани нь "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тесэл"-ийн хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Сангийн Яам болон Зам Тээврийн Хөгжлийн Яамтай 11,610 сая төгрөгийн дунтэй "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-г байгуулсан ба энэхүү эх үүсвэрээр улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл нийлүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Санхүүгийн түрээсийн авлагын эргэн төлөлтөөс хамааран уг санхүүжилтийн эргэн төлөх хугацаа болон үнийн дүн нь харилцан адилгүй байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**14. Зээл (үргэлжлэл)**

(2) Урт хугацаат зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна:

<b>Зээлдүүлэгч</b>	<b>Валют</b>	<b>Хүүгийн түвшин</b>	<b>Авсан огноо</b>	<b>Дуусах огноо</b>	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
Монгол Улсын Хөгжлийн банк	Ам.Доллар Иен	3.60%	7/28/2017	7/28/2022	17,826,542	20,943,553
		5.95%	11/16/2017	5/29/2020	2,964,207	5,331,612
		4.89%	4/10/2018	4/10/2021	2,185,185	-
		4.89%	5/24/2018	4/10/2021	1,185,725	-
		6.50%	9/12/2018	9/12/2023	2,601,258	-
		6.50%	11/13/2018	9/12/2023	2,623,768	-
		6.50%	10/18/2018	9/12/2023	4,790,052	-
		3.12%	6/20/2018	6/20/2023	14,193,616	-
		7.42%	12/6/2018	12/6/2023	481,898	-
		2.25%	12/21/2017	7/28/2028	<u>8,248,643</u>	<u>2,308,666</u>
Сангийн Яам (*)	Төгрөг				<b><u>57,100,894</u></b>	<b><u>28,583,830</u></b>

**15. Хувьцаат капитал**

	<b>Энгийн хувьцааны тоо</b>		<b>12 дугаар сарын 31-нээрх</b>	
	<b>2018</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2017</b>
01 дүгээр сарын 01-нээрх	10,000	10,000	10,000,000	10,000,000
Нэмж гаргасан	-	-	-	-
12 дугаар сарын 31-нээрх	<u>10,000</u>	<u>10,000</u>	<u>10,000,000</u>	<u>10,000,000</u>

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хувьцаат капитал нь 10 тэрбум төгрөг бөгөөд нэг бүр нь 1 сая төгрөгийн үнэтэй 10,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

**16. Хүүгийн орлого**

	<b>2018</b>	<b>2017</b>
Түрээсийн авлага	3,055,137	646,267
Хугацаатай хадгаламж	1,133,424	144,117
Харилцах данс	51,313	56,200
Засгийн Газрын бонд	-	167,997
	<b><u>4,239,874</u></b>	<b><u>1,014,581</u></b>

**17. Хүүгийн зардал**

	<b>2018</b>	<b>2017</b>
Зээл	(2,176,437)	(556,785)
Санхүүгийн түрээс	(9,934)	-
	<b><u>(2,186,371)</u></b>	<b><u>(556,785)</u></b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**18. Ерөнхий удирдлагын зардал**

	<b>2018</b>	<b>2017</b>
Цалингийн зардал	(636,703)	(199,628)
Нийгэм, эрүүл мэндийн даатгалын зардал	(78,542)	(22,307)
Томилолтын зардал	(115,425)	(35,803)
Түрээсийн зардал	(87,857)	(45,949)
Элэгдэл болон хорогдолын зардал	(39,271)	(13,791)
Тээвэр, шатахууны зардал	(10,417)	(5,317)
Бусад зардал	(89,717)	(25,644)
	<b>(1,057,932)</b>	<b>(348,439)</b>

**19. Бусад үйл ажиллагааны орлого (зардал), цэвэр**

	<b>2018</b>	<b>2017</b>
Ханшийн тэгшитгэлийн хэрэгжсэн олз	232,078	45,354
Ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй олз (гарз)	153,097	(47,256)
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	1,338	-
Бусад орлого	636	-
	<b>387,149</b>	<b>(1,902)</b>

**20. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бүуралт**

	<b>2018</b>	<b>2017</b>
Түрээсийн авлага	(507,894)	-
Хугацаатай хадгаламж	(40,272)	-
	<b>(548,166)</b>	<b>-</b>

**21. Орлогын татварын зардал**

	<b>2018</b>	<b>2017</b>
Татварын зардал	127,161	20,032
	<b>127,161</b>	<b>20,032</b>

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон өдрийн татварын өмнөх орлогоос татварын нийтлэг хувь хэмжээгээр тооцоолсон орлогын татварын зардлыг дараах байдлаар тооцоолно:

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**21. Орлогын татварын зардал (үргэлжлэл)**

	<b>2018</b>	<b>2017</b>
Татварын өмнөх ашиг	834,554	107,455
Нийтлэг хувь хэмжээгээр тооцсон татвар	83,455	10,746
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	59,015	6,054
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(133,783)	(16,800)
Тусгай хувь хэмжээгээр ногдох татвар	118,474	20,032
<b>Тайлант жилийн орлогын татварын зардал</b>	<b>127,161</b>	<b>20,032</b>

Компани нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу З тэрбум хүртэлх төгрөгийн татвар ногдуулах орлогод 10%-ийн татвар, З тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол З тэрбуунаас давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж татвар ногдуулж, төлөх үүрэгтэй. Хүүгийн орлогод тооцох татварын хувь хэмжээ 10% байна.

**22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ**

**22.1 Холбоотой талуудын харилцан хамаарал**

Дараах байгууллагууд нь Компанийн холбоотой талууд болно. Үүнд:

**Байгууллагын нэр**

Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ)  
Сангийн яам (СЯ)  
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (МУХБ)  
Ди Би Эссет Менежмент УЦК ХХК  
Төрийн Банк ХХК  
Бусад засгийн газрын байгууллагууд

**Харилцан хамаарал**

Дээд шатны хяналт тавих байгууллага  
Дунд шатны хяналт тавих байгууллага  
Толгой компани  
Толгой компанийн охин компани  
МУЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллага  
МУЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллага

**22.2 Холбоотой талуудын үлдэгдэл**

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

**Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:**

	<b>2018</b>	<b>2017</b>
Харилцах данс	69,643	4,854
Зээл	56,688,607	30,384,031
Анхны хөрөнгө оруулалт	-	10,000,000

**Сангийн Яам:**

Төслийн санхүүжилтийн зээл	9,435,521	3,241,549
----------------------------	-----------	-----------

**Төрийн Банк ХХК:**

Харилцах данс	268,460	125,550
Хугацаатай хадгаламж	-	3,238,977

**Бусад засгийн газрын байгууллагууд:**

Түрээсийн авлага	39,755,687	21,656,506
------------------	------------	------------

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)**

**22.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ**

Дараах ажил гүйлгээнүүдийг холбоотой талуудтай хийсэн:

	<b>2018</b>	<b>2017</b>
<b>Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:</b>		
Зээлийн хүүгийн зардал	1,999,238	556,785
<b>Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК</b>		
Үндсэн хөрөнгийн борлуулалт	-	61,413
Зардлын нөхөн төлбөр	-	2,803
<b>Сангийн Яам:</b>		
Зээлийн хүүгийн зардал	174,561	1,549
<b>Төрийн Банк ХХК:</b>		
Харилцах дансны хүүгийн орлого	19,558	-
Хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого	291,976	29,265
<b>Бусад засгийн газрын байгууллагууд:</b>		
Түрээсийн авлагын хүүгийн орлого	1,812,161	538,049
Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцлөөр хийгдсэн.		
<b>22.4 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал</b>		
Удирдах гол албан тушаалтнууд нь Гүйцэтгэх захирал болон нэгжүүдийн захирлууд юм. Үндсэн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна. Үүнд:		
	<b>2018</b>	<b>2017</b>
Цалин урамшуулал	264,615	104,929
	<b>264,615</b>	<b>104,929</b>

Удирдах гол албан тушаалтнуудын цалин урамшуулал нь цалин болон ажил олгогчоос төлсөн нийгмийн, эрүүл мэндийн даатгалаас бүрдэнэ.

**23. Санхүүгийн түрээс**

Санхүүгийн түрээсийн нийт хөрөнгө оруулалт болон хамгийн бага түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн хоорондын тохируулга дараах байдалтай байна:

	<b>2018</b>	<b>2017</b>
Санхүүгийн түрээсийн нийт хөрөнгө оруулалт		
Нэг жилээс бага	13,961,656	6,949,117
Нэгээс таван жил хүртэл	68,753,986	34,220,834
	<b>82,715,642</b>	<b>41,169,951</b>
Xүү	(14,939,385)	(7,610,854)
Хамгийн бага түрээсийн төлбөрийн ӨҮЦ	<b>67,776,257</b>	<b>33,559,097</b>
Хамгийн бага түрээсийн төлбөрийн ӨҮЦ		
Нэг жилээс бага	11,440,022	521,280
Нэгээс таван жил хүртэл	56,336,235	33,037,817
	<b>67,776,257</b>	<b>33,559,097</b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага**

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашигласнаар дараах эрсдэлүүдийг хүлээж байдаг.

- Зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Зах зээлийн эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн Компанид нөлөөлөх нөлөөлөл, уг эрсдэлийг тооцоолох, Компаний зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн Компанийн хөрөнгийн удирдлагын талаарх мэдээллийг агуулсан. Компани нь эрсдэлийн удирдлагыг хянах үүднээс Лизингийн хороог байгуулсан.

**24.1 Зээлийн эрсдэл**

Компанийн ТУЗ нь зээлийн эрсдэлийн удирдлагын үүрэг хариуцлагыг Түрээсийн Хороонд шилжүүлсэн. Түрээсийн Хороо нь сар бүрийн эцэст Түрээсийн Хорооны хурлаар түрээсийн зээлийн багцын чанар, гүйцэтгэлийг хянан хэлэлцдэг бөгөөд түрээсийн зээлийн багц дахь бүх зээлийн эрсдэлийг удирдах, хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиromжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянах байдаг.

Компани өөрийн сургалт, удирдлагын стандарт болон журамыг ашиглан ажилчид нь өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ойлгосон, дэг журамтай, бүтээлч хяналтын орчныг бий болгохоор зорьж ажилладаг.

Зээлийн эрсдэл гэдэг нь Түрээслэгч тал Санхүүгийн Түрээсийн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас Компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд энэ нь голдуу Компанийн түрээсийн үйл ажиллагааны авлагаас үүдэлтэй байдаг.

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь банкны харилцах данс, хүүгийн авлага ба түрээсийн барьцаа төлбөрөөс бүрдэнэ.

Санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ нь хамгийн их зээлийн эрсдэлийг илэрхийлнэ. Санхүүгийн тайлагналын өдрөөрх хамгийн их зээлийн эрсдэл дараах байдалтай байна:

	<b>2018.12.31</b>	<b>2017.12.31</b>
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	769,521	5,650,780
Хугацаатай хадгаламж	8,200,204	4,444,698
Түрээсийн авлага	67,776,257	33,559,097
Дансны болон бусад авлага	79,448	8,499
Бусад хөрөнгө	51,917	6,460
	<b>76,877,347</b>	<b>43,669,534</b>

*Мөнгөн хөрөнгө болон хугацаатай хадгаламж*

Компанийн зээлийн эрсдэлд өртөх байдал нь гол төлөв Компанийн хадгаламж байршуулсан банкуудын онцлог шинж чанараас хамаардаг. Компанийн удирдлага нь банк тус бүрийн зээл төлөх чадварыг тогтоох зээлийн бодлогыг нэвтрүүлсэн.

Компанийн үнэлгээнд гадны үнэлгээ, хэрэв боломжтой бол санхүүгийн тайлангууд, зээлийн байгууллагын мэдээлэл, зах зээлийн мэдээлэл болон зарим тохиолдолд Монголбанкны лавлагaa орно. Дансны дээд хязгаар нь банк тус бүр дээр тогтоогддог ба тогтмол хянаагддаг.

Компани нь Монгол Улсын эдийн засгийн орчин, банкны салбарыг ажиглаж, эдийн засгийн нөхцөл байдалд аливаа хүндрэл үүсэх тохиолдолд үүсч болох эрсдэлийг хязгаарлах бодлого баримталдаг. Компанийн банкны дансууд хугацаа хэтрэлтгүй байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**24.1 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

*Түрээсийн авлага*

Компанийн зээлийн эрсдэл нь голдуу худалдан авагч тус бүрийн хувийн онцлогоос хамааралтай байдаг. Удирдлага нь зээлийн эрсдэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс болох харилцагчдын үйл ажиллагаагаа явуулж буй улс орон болон тухайн салбарын төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл зэрэг Компанийн харилцагчдын онцлогыг харгалзан үздэг.

Компанийн стандарт нөхцлийг харилцагчдад санал болгохоос өмнө компани нь шинэ харилцагч тус бүрийн зээл төлөх чадварыг тусгайлан шинжилж, зээлийн бодлогоо боловсруулдаг. Компанийн хяналтад боломжтой бол гадаад үнэлгээ, санхүүгийн тайлан, зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, бизнесийн салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд банкны лавлагаа, тодорхойлолт багтдаг.

Харилцагч тус бүрээр төлбөр төлөх дэлгэрэнгүй хуваарь гаргах байдлаар түрээсийн авлагаас хүлээн зээлийн эрсдэлийг хязгаарладаг. Компани харилцагчийн зээлийн эрсдэлийг тус бүрт нь хянадаг. Компанийн стандарт, бодлого журамд зааснаар санхүүгийн түрээсийн гэрээний төлбөр бүрэн төлгөдөж дуусах хүртэлх хугацаанд түрээслэгчийн санхүүгийн хөрөнгийг эзэмших эрхтэй байх ёстой. Компани нь түрээслэгчийн зээлийн эрсдэл болон санхүүгийн түрээсийн эх үүсвэрээс хамаараад урьдчилгаа төлбөрийг 15 – 30% хооронд байршуулахыг шаарддаг.

Компани нь мөн зээлийн төвлөрлийн эрсдэлийг хянаж байдаг ба зээлийн эрсдэл нь голдуу хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарт төвлөрсөн байдаг.

2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлийн эрсдэл болон барьцаа хөрөнгө нь дараах байдалтай байна.

	<b>2018.12.31</b>		<b>2017.12.31</b>	
	<b>Зээлийн эрсдэл</b>	<b>Барьцаа хөрөнгө</b>	<b>Зээлийн эрсдэл</b>	<b>Барьцаа хөрөнгө</b>
Түрээсийн авлага	<b>67,776,257</b>	<b>84,775,580</b>	<b>33,559,097</b>	<b>38,581,886</b>
	<b><u>67,776,257</u></b>	<b><u>84,775,580</u></b>	<b><u>33,559,097</u></b>	<b><u>38,581,886</u></b>

2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хугацаа хэтэрсэн болон үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө дараах байдалтай байна:

<b>2018.12.31</b>	<b>Хугацаа ч хэтэрэгүй үнэ цэнэ ч буураагүй</b>	<b>Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй</b>	<b>Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буурсан</b>	<b>Нийт</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	769,521	-	-	769,521
Мөнгөн хадгаламж	8,200,204	-	-	8,200,204
Түрээсийн авлага	66,107,211	-	1,669,046	67,776,257
Дансны болон бусад авлага	79,448	-	-	79,448
Бусад авлага	51,917	-	-	51,917
	<b><u>75,208,301</u></b>	<b><u>-</u></b>	<b><u>1,669,046</u></b>	<b><u>76,877,347</u></b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**24.1 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

	Хугацаа ч хэтэрэгүй Үнэ цэнэ ч буураагүй	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буурсан	Нийт
<b>2017.12.31</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,650,780	-	-	5,650,780
Мөнгөн хадгаламж	4,444,698	-	-	4,444,698
Түрээсийн авлага	33,559,097	-	-	33,559,097
Дансны болон бусад авлага	8,499	-	-	8,499
Бусад авлага	6,460	-	-	6,460
	<b>43,669,534</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>43,669,534</b>

**24.2 Хөрвөх чадварын эрсдэл**

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ билүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компаний нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бутцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

Дараах хүснэгтэнд Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг төлөгдөх үлдсэн хугацаанд нь үндэслэн холбогдох дуусгавар болох хугацаагаар нь бүлэглэн ангилсан шинжилгээг харууллаа:

	2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр				
	3 сар хүртэлх	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5 жилээс дээш
<b>Санхүүгийн хөрөнгө</b>					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	769,606	-	-	-	-
Хугацаатай хадгаламж	3,903,328	-	-	4,552,935	-
Түрээсийн авлага	3,223,269	3,925,465	8,193,246	61,638,576	5,735,086
Дансны болон бусад авлага	79,448	-	-	-	-
	<b>7,975,651</b>	<b>3,925,465</b>	<b>8,193,246</b>	<b>66,191,511</b>	<b>5,735,086</b>
					<b>92,020,959</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>					
Зээл	2,610,986	2,540,703	7,926,305	62,184,794	4,548,140
Дансны болон бусад өглөг	5,993,567	-	-	-	-
	<b>8,604,553</b>	<b>2,540,703</b>	<b>7,926,305</b>	<b>62,184,794</b>	<b>4,548,140</b>
					<b>85,804,495</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>(628,902)</b>	<b>1,384,762</b>	<b>266,941</b>	<b>4,006,717</b>	<b>1,186,946</b>
					<b>6,216,464</b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**24.2 Хөрвөх чадварын эрсдэл (үргэлжлэл)**

	2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр					<b>Нийт</b>
	<b>3 сар хүртэлх</b>	<b>3-6 сар жил</b>	<b>5 жилээс дээш</b>	<b>1-5 жил</b>	<b>6 сараас 1</b>	
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,650,871	-	-	-	-	5,650,871
Мөнгөн хадгаламж	-	4,444,698	-	-	-	4,444,698
Түрээсийн авлага	-	-	-	36,667,701	4,502,250	41,169,951
Дансны болон бусад авлага	8,499					8,499
	<b>5,659,370</b>	<b>4,444,698</b>		<b>36,667,701</b>	<b>4,502,250</b>	<b>51,274,019</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Зээл	931,334	4,109,928	-	26,275,164	2,310,216	33,626,642
Дансны болон бусад өглөг	62,930	-	-	-	-	62,930
	<b>994,264</b>	<b>4,109,928</b>		<b>26,275,164</b>	<b>2,310,216</b>	<b>33,689,572</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>4,665,106</b>	<b>334,770</b>		<b>10,392,537</b>	<b>2,192,034</b>	<b>17,584,447</b>

**24.3 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, санхүүгийн түрээс болон гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлогод сергэөр нелөөлөх эрсдэл юм. Компани нь гадаад валютын эрсдэлгүй ба улмаар гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ гэж өгөгдөөгүй болно.

Компанийн санхүүгийн байдал болон мөнгөн урсгалын тайлан нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нэлэөллийг тусгасан байdag.

<b>2018.12.31</b>	<b>Төгрөгт хөрвүүлсэн</b>	<b>Гадаад валютаарх</b>	<b>Нийт</b>
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	538,585	230,936	769,521
Хугацаатай хадгаламж	7,678,857	521,347	8,200,204
Түрээсийн авлага	10,469,825	57,306,432	67,776,257
Дансны болон бусад авлага	27,431	52,017	79,448
	<b>18,714,698</b>	<b>58,110,732</b>	<b>76,825,430</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Зээл	9,435,523	56,688,607	66,124,130
Санхүүгийн түрээсийн өглөг	134,234	-	134,234
Дансны болон бусад өглөг	5,920,979	72,588	5,993,567
	<b>15,490,736</b>	<b>56,761,195</b>	<b>72,251,931</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>3,223,962</b>	<b>1,349,537</b>	<b>4,573,499</b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**24.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

<b>2017.12.31</b>	<b>Төгрөгт хөрвүүлсэн</b>	<b>Гадаад валютаарх</b>	<b>Нийт</b>
<b>Санхүүгийн хөрөнгө:</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,036,382	614,488	5,650,870
Хугацаатай хадгаламж	4,444,698	-	4,444,698
Түрээсийн авлага	3,098,727	30,460,370	33,559,097
Дансны болон бусад авлага	8,499	-	8,499
	<b>12,588,306</b>	<b>31,074,858</b>	<b>43,663,164</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Зээл	3,241,550	30,385,092	33,626,642
Дансны болон бусад өглөг	62,903	27	62,930
	<b>3,304,453</b>	<b>30,385,119</b>	<b>33,689,572</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>9,283,853</b>	<b>689,739</b>	<b>9,973,592</b>

2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн гадаад валют 10 хувиар чангараах эсвэл сулрахад дэлгэрэнгүй орлогыг дараах байдлаар нэмэгдүүлэх(бууруулах) төлөвтэй байна. Энэ шинжилгээ нь бусад бүх эрсдэлийн хүчин зүйлсийг тогтмол гэж авч үзсэн болно.

	<b>10%-иар чангараах</b>	<b>10%-иар сулрах</b>
<b>2018</b>		
12 дугаар сарын 31-ний өдрөөр	121,458	(121,458)
<b>2017</b>		
12 дугаар сарын 31-ний өдрөөр	62,077	(62,077)

**Хүүгийн түвшний эрсдэл**

Хүүний түвшний эрсдэл нь ирээдүйд хадгаламж, түрээсийн авлага болон зээлийн хүүгийн хэлбэлзлээс болж хүүгийн түвшин хувьсан өөрчлөгдэх эрсдэлийг хэлнэ. Хүүгийн түвшний эрсдэлийн зорилго нь санхүүгийн өртөг болон хүүгийн түвшний тодорхойгүй байдлыг бууруулах юм.

Компанийн хүүгийн түвшний зах зээлийн эрсдэл нь гол төлөв Компанийн зээлээс хамааралтай юм. Компанийн бодлого нь эрсдэлийг бууруулах үүднээс тогтмол хүүтэй зээл авахаар зорьсон байдаг. Санхүүгийн тайлагналын өдрөөр, Компанийн хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүд бүгд тогтмол хүүтэй байв.

**24.4 Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ**

Компанийн санхүүгийн хэрэгслүүр нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн банкны хадгаламж, түрээсийн авлага, дансны болон бусад авлага барьцаа төлбөрөөс бурдэнэ.

Удирдлага санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК  
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**25. Капиталын эрсдэлийн удирдлага**

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд банкин дахь дансны үлдэгдэл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог.

Компанийн капиталын бүтэц нь банкин дахь дансны үлдэгдэл, зээл, эздийн өмч ба өөрийн хөрөнгөөс бурдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан ба хуриатлагдсан ашгаас тус тус бүрддэг.

**26. Балансын дараах үйл явдал**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлант хугацааны эцсээс хойш Компанийн санхүүнийн тайланд тодруулагдах буюу залруулагдах материаллаг үйл явдал болоогүй.

**27. Монгол орчуулга**

Энэхүү санхүүгийн тайланг Англи болон Монгол хэл дээр бэлтгэсэн болно. Монгол болон Англи хэл дээрх хувилбаруудын хооронд утга болон агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбарыг баримтална.